



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2023.08.09 № 288

танай _____-ны № _____-т

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.ЭНХБОЛД ТАНАА

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар гүйцэтгэсэн "Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 43 хуудастай.

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР





ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ГАДААДЫН
ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ 90 ХУВЬТАЙ, НИЙТ
ХӨРӨНГИЙН 14.3 ХУВИЙГ БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ
ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД:

АРА-2023/25-01-ШТА-ГА



ЦЭЦЭРЛЭГ ХОТ
2023

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141 Цахим хаяг: baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860 Цахим хаяг: nerguibaatar@audit.gov.mn
Багийн ахлагч: Ахлах аудитор: Г.Цог-Эрдэнэ
Утас: 9921-0906 Цахим хаяг: Tzog-erdeneg@audit.gov.mn
Аудитор: Л.Соёлмөнх
Утас: 9905-1581 Цахим хаяг: soyolmunkhl@audit.gov.mn
Аудитор: Н.Энхчимэг
Утас: 8989-1150 Цахим хаяг: enkhchimegn@audit.gov.mn
Аудитор: А.Пүрэвцэцэг
Утас: 9974-6363 Цахим хаяг: purevtsetsega@audit.gov.mn
Аудитор: Б.Азантунгалаг
Утас: 94658633 Цахим хаяг: Azantungalagb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хүүдас: www.audit.mn



<p>Тайлан бэлтгэсэн: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Товчилсон үгийн тайлбар ➤ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 	<p>2 4-6</p>
<p>Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар</p> <p>Ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ Аудитор Н.Энхчимэг Л.Соёлмөнх А.Пүрэвцэцэг Б.Азантунгалаг</p> <p>2023 оны 08 дугаар сар</p> <p>Уг тайланг www.audit.mn сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах зүйл байвал 7033-2860 дугаарын утас, 7033- 3141 дугаарын факсаар харилцана уу</p> <p>Хаяг: Эрдэнэбулган сум Аймгийн ЗДТГ-ын байр 3-р давхар 314 тоот</p>	<p>БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА.</p> <p>A1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдаж байна.</p> <p>A2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй байна.</p> <p>БҮЛЭГ 2. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийг бүрэн ашиглаагүй байна.</p> <p>B1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зорилго, зорилт нь салбарын бодлоготой уялдсан байна.</p> <p>B2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажилласан байна.</p> <p>БҮЛЭГ 3. Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөө багатай байна.</p> <p>B.1. Зарим зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p>B.2. Гадаадын зээлээр хэрэгжсэн зарим төслийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцоогүй байна.</p> <p>Дүгнэлт Зөвлөмж Тайлан баталгаажуулсан тушаал Холбогдох байгууллагын санал Тайлангийн хавсралтууд</p>	<p>7 8 10 11 15 18 19 21 22 25 27</p>



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох заалтаар харуулбал.	12
2	Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт	14

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг сумдаар харуулбал /2019-2022 он/	5
2	Гадаадын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байдал	8
3	Гадаадын зээлийн төлөлт /2023 оны 07 дугаар сарын байдлаар/	9
4	Аймгийн Засаг даргын дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байдал	9
5	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслөөр 2019-2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	11
6	Гадаадын тусламжаар хэрэгжсэн хөрөнгийн ашиглалтын байдал	13
7	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн шилэн дансны хэрэгжилт	17
8	2020-2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд	
9	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслөөс 2019-2022 онд хэрэгсэн төсөл арга хэмжээ	18
10	Бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгийн жагсаалт	19

,



Аудит хийсэн үндэслэл, зорилго, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

“Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашигласан;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцооны үр нөлөө;

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитад аймгийн ЗДТГ, Хүнс, хөдөө аж ахуйн газар, ОНӨГ, сумдын ЗДТГ, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт 2018-2022 оны гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн төслийн нэгж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн холбогдох үйл ажиллагаа, гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнг хамруулан шалгалаа.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-300, 3000-3200 Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-3:2020, MNS 6817-5:2020 MNS 6817-7:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, Нийцлийн аудитын холбогдох стандартад заасан арга зүйг ашиглав.

Аудитаар салбарын бодлого, тогтолцоо, үйл ажиллагаатай холбоотой баримт материалыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтан, төсөл хэрэгжүүлэгчээс асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:



- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль (2015 он);
- Шилэн дансны тухай хууль (2014 он);
- Өрийн удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

АУДИТ ХИЙХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Нэргүйбаатар үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Цог-Эрдэнэ, аудитор Н.Энхчимэг, Л.Соёлмөнх, А.Пүрэвцэцэг, Б.Азантунгалаг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 08 дугаар сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАХ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын тайлан нь аудитын зорилт, дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал болон хавсралт хэсгээс бүрдэнэ.

Гүйцэтгэлийн аудитын тайлан аудитын асуудлын шинжилгээний 4 дэх түвшний асуулт бүрд хариулт өгч тэмдэглэгээ хийсэн ба 3 дахь түвшний асуултын хүрээнд ерөнхийдөө ангилагдан бичигдсэн болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх” заалтыг үндэслэн хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна. Улсын хэмжээнд 2018-2022 онд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн 9 төсөл хөтөлбөрөөс 4 нь Архангай аймагт хэрэгжсэн байна. Дараах төсөл, хөтөлбөрүүд орон нутагт хэрэгжээгүй. Үүнд:

1. “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” /зээл, буцалтгүй тусламж/ 3895-MON(COL), 9205-MON



2. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл МОН-П9
3. Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл /буц. тусламж/ 9192-MON, 0684-MON
4. Экспортыг дэмжих төсөл /зээл/ 5879-MN
5. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл / зээл/ 6508-MN

Архангай аймагт гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжсэн 4 төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн байдлыг танилцуулбал: /Дэлгэрэнгүйг Хавсралт №1 -ээс үзнэ үү/

1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээл 2000001604

- Төслийн хүрээнд 2019-2022 онд нийт 118 төсөл, арга хэмжээг 2,634.0 сая төгрөгийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн байна. Дэлгэрэнгүй Хавсралт №2-оос үзнэ үү.

Хүснэгт 1. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хүрээнд буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг сумдаар харуулбал /2019-2022 он/

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	2020 он		2020 он		2021 он		2022 он		2020-2022 онд хэрэгжсэн нийт төслийн дүн	
		Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	тоо	мөнгөн дүн
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	Хайрхан	16	310.8	3	25.8					19	336.6
2	Эрдэнэмандал	15	145.7	4	74.8	2	56.5		17.4	21	294.4
3	Төвшрүүлэх	10	141.4	5	106.9	1	6.8		16.6	16	271.7
4	Цэнхэр			3	53.4					3	53.4
5	Хотонт			4	74.4	2	104.3		16.6	6	195.3
6	Хашаат			4	74.4					4	74.4
7	Өгийнуур			4	31.9					4	31.9
8	Өлзийт			4	31.9	1	28.2		17.4	5	77.5
9	Батцэнгэл			6	113.2					6	113.2
10	Ихтамир			4	75.3	1	6.8		16.4	5	98.5
11	Тариат			1	20.5					1	20.5
12	Өндөр-Улаан			2	41.1					2	41.1
13	Чулуут			3	61.7					3	61.7
14	Цэцэрлэг			4	74.8	1	28.2		17.4	5	120.4
15	Жаргалант			2	40.9	1	28.2		17.4	3	86.5
16	Хангай			1	20.5			1	138.1	2	158.6
17	Булан			-		1	6.8		16.6	1	23.4
18	Эрдэнэбулган			6	218.1	5	170.7	1	186.0	12	574.8
Дүн		41	597.9	60	1,139.6	15	436.5	2	459.9	118	2,634

- Төслөөс 2020-2023 онд орон нутгийн Хаан банкны салбараар дамжуулан 44 иргэн, ААН-д 931.9 сая төгрөгийн, Төрийн банкны салбараар дамжуулан 38 иргэнд 351.0 сая төгрөгийн нийт 82 иргэн, ААН-д 1,282.9 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ. /Эх сурвалж: Архангай аймаг дахь Хаан банкны салбарын 2023 оны 07 сарын 25-ны өдрийн 5135/422 тоот албан бичиг, аймаг дахь Төрийн банкны 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 35/459 дугаар албан бичгийг үндэслэв/
2. “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/ №112/00236091/210034-1
Төслөөс 2021 онд Батцэнгэл, Хотонт сумын 2 иргэн, Төвшрүүлэх сумын 2 ААН-д Беларусь улсын трактор, хадуур тармуур, дөрвөлжин хаман боогч зэрэг 9 ширхэг техник, тоног төхөөрөмжийг 108,220 еврогийн хөнгөлөлттэй зээлээр олгожээ. Гадаадын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 4 иргэн, ААН-үүд нь 2023 оны 07 дугаар сарын байдлаар 64,725 еврогийн зээлийг эргэн төлсөн байна.
 3. Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох /зээл/ МОН-3338



Орон нутагт Хас банкны салбараар дамжуулан зээлийн батлан даалтын сангийн 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрээр 1 иргэн хамрагдаж 10,800.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр зээлийг бүрэн төлж дуусгасан байна. /Эх сурвалж: Архангай аймаг дахь Хас банкны салбарын 2023 оны 07 сарын 21-ний өдрийн 14/345 тоот албан бичиг/

4. "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт" төсөл /зээл/ 3287-MON, 3288-MON SF хүрээнд:

- Архангай аймгийн Цахир, Хангай, Тариат сумдад сүү цуглуулж боловсруулахаар төлөвлөсөн Улаанбаатар хотын “Глобал номадик продактс” ХХК-д 2.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон мэдээлэлтэй боловч 2023 онд орон нутагт үйл ажиллагаа явуулаагүй байна.
- Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих ТА-8960 МОН дэд төслөөс малчид, фермерүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 онд сүүний аж ахуй эрхлэгч 5 сумын 33 малчин айл өрхөд тус бүр 9 нэр төрлийн 1,709.5 мянган төгрөгийн өртөгтэй 12 ширхэг, 3 сумын 3 хоршоонд тус бүр 10 нэр төрлийн 26 ширхэг 11,838,004.36 төгрөгийн өртөгтэй нийтдээ 91,927.5 мянган төгрөгийн сүү боловсруулах багц тоног төхөөрөмжийг, 1 хоршоонд 141,985.0 мянган төгрөгийн ноосны багаж, богийн арьсыг халимлах төхөөрөмж, химийн бодис зэргийг буцалтгүй тусламжаар нийлүүлжээ.
- Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжил дэд төслөөс 2020 онд 160.8 сая төгрөгөөр инженерийн хийцтэй 7 худаг шинээр барьж байгуулсан байна.

ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

Аудитын явцад шалгагдагч байгууллагуудын хариуцсан албан хаагч, мэргэжилтнүүд солигдсоноос шалтгаалан зарим баримт, судалгаа авах боломжгүй байдал үүссэн, иргэн, ААН-д олгосон зээлийн мэдээллүүд тодорхой бус зэргээр аудитад хүндрэл бэрхшээл үүссэн болно.



БҮЛЭГ 1. ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛИЙГ ҮР ДҮНТЭЙ АШИГЛАЖ БАЙНА.

A1. Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө, аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдаж байна.

A1.1. Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой нийцсэн төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулсан байна.

Архангай аймгийн Хөдөө аж ахуйн салбарт 2018-2023 оны байдлаар гадаадын 3 төслөөс 76 иргэн, 11 ААН-ийг шалгаруулж 1,293,700.0 мянган төгрөгийн болон 108,220 еврогийн хөнгөлөлттэй зээл олгожээ.

Хүснэгт 2. Гадаадын хөнгөлөлттэй зээлд хамрагдсан байдал

№	ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭР	Төслийн код	Зээл олгосон он	Зээл олгосон /тоо/		Олгосон зээлийн дүн	
				Иргэн	ААН	Мянган төгрөгөөр	Еврогоор
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээл	2000001604	2020-2023 он	73	9	1,282,900.0	-
2	“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/	№112/002360 91/210034-1	2021	2	2		108,220
3	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох	МОН-3338	2018	1		10,800.0	
Нийт дүн				76	11	1,293,700.0	108,220

Дээрх 3 төсөлд хамрагдсан 76 иргэн, 11 ААН-ийн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Азийн хөгжлийн банкны хориглосон хөрөнгө оруулалтын салбарт хамаарахгүй, байгаль орчин, хөрс, агаар ус, ой, ургамал, амьтанд ямар нэг сөрөг нөлөөгүй, Хөдөө аж ахуйн салбарын бодлоготой нийцсэн гэж үзэн төсөл хэрэгжүүлэгч нэгжээс байгаль орчин, нийгмийн дүгнэлт гаргаж аймаг дахь Хаан банк, Хас банк, Төрийн банкны салбар төвүүдээр дамжуулан хөнгөлөлттэй зээл олгожээ.

A1.2. Төлөвлөлтийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээнд зээл олгосон эсэхийг орон нутагт үзэх боломжгүй байна.

Гадаадын 3 төслийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, ААН-ийн төсөл, холбогдох баримт материалыг төсөл хэрэгжүүлэгч нэгжээс сонгон шалгаруулж шаардлага хангасан эсэхийг үнэлж, дүгнэлт гаргасан бөгөөд орон нутгийн арилжааны банк нь өөрийн шалгуур үзүүлэлтийг хангасан иргэн, ААН-д зээл олгожээ. Иймд төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг орон нутагт үзэх боломжгүй байна.



A2. Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, хэрэгжилт үр дүнтэй байна.

A2.1. Зээлийн хөрөнгийг ашиглагч нэг иргэн гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй, зээлийн төлөлтөө хийгээгүй байна.

Хөдөө аж ахуйн салбарт гадаадын төслөөс иргэн, ААН-д олгосон зээлийн эргэн төлөлтийг 2023 оны 07 дугаар сарын байдлаар авч үзэхэд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээлийн төлөлт 43.4 хувь, “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-ийн зээлийн төлөлт 59.8 хувь, Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох төслийн зээл 100 хувь төлөгджээ. Дэлгэрэнгүйг хавсралт №3-оос үзнэ үү

Хүснэгт 3. Гадаадын зээлийн төлөлт /2023 оны 07 дугаар сарын байдлаар/

№	ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН НЭР	Төслийн код	Зээл олгосон огноо	Зээл олгосон /тоо/		Олгосон зээлийн дүн		Зээлийн үлдэгдэл		Эргэн төлөлтийн байдал
				Иргэн	ААН	Мянган төгрөгөөр	Евро	Мянган төгрөгөөр	Евро	
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ зээл	2000001604	2020-2023 он	73	9	1,282,900.0	-	726,412.00		7 иргэний зээл хаагдсан. 66 иргэн, 9 ААН-ийн зээл хэвийн ангилалтай.
2	“Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл” /зээл/	№112/00236091/210034-1	2021	2	2		108,220		43,495	2 ААН, 1 иргэн нь зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу төлөлтөө хийсэн. Харин 1 иргэн нь гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлээгүй.
3	Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг бий болгох	МОН-3338	2018	1		10,800.0				2021.06.15-ны өдөр төслийн зээлээ бүрэн төлж барагдуулж гэрээнд заасан үүргээ тогтоосон хугацаанд биелүүлсэн байна.
Нийт дүн				76	11	1,293,700.0	108,220	726,412.00	43,495	

Дээрх төслөөс зээл авсан иргэн, ААН-ийн гэрээнд заасан үүргийн хэрэгжилтийг аймаг дахь Хаан банк, Төрийн банк, Хас банкны салбараас зээлийн гэрээнд тусгасан зориулалтын дагуу зарцуулсан байдал, зээлийн эргэн төлөлт, төслийн хэрэгжилт, бизнесийн үйл ажиллагаанд хагас жил тутам хяналт хэрэгжүүлсэн байна. /Эх сурвалж: Архангай аймаг дахь Хас банкны салбарын 2023 оны 07 дугаарын 21 өдрийн 14/345 дугаар албан бичиг, Хаан банкны салбарын 2023 оны 07 сарын 25-ны өдрийн 5135/422 тоот албан бичиг, Төрийн банкны салбарын 2023 оны 07 дугаар сарын 21-ны өдрийн 35/459 дугаар албан бичгийг үндэслэв үндэслэв/

Харин “Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл”-өөс хөнгөлөлттэй зээл авсан иргэн Д.Баатархүү нь Бел ТТ-21/0108-06 дугаартай зээлийн гэрээнд заасан хуваарийн дагуу 2022 оны 3,913.67 еврогийн зээлийн эргэн төлөлтийг хийгээгүй байна. Энэ нь Өрийн удирдлагын тухай хуулийн 32.1¹, "Трактор,

¹ "Дэд болон эцсийн зээлдэгч нь дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй"



хөдөө аж ахуйн техник худалдах, худалдан авах гэрээ"-ний 2.3², 2.4³, 2.6⁴ дахь заалттай нийцэхгүй байна.

Гэрээний үүргийн хэрэгжилтийг хангаж 2022 оны 3,913.67 еврогийн зээлийг эргэн төлөх хугацаатай албан шаардлагыг зээлдэгч Д.Баатархүүд хүргүүлэв.

A2.2. Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт үр дүнтэй байна.

Архангай аймгийн хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын хөнгөлөлттэй зээлийн ашиглалтын байдалд орон нутаг дахь арилжааны банкнаас хяналт тавьж ажилласан байна. Төсөл тус бүрийн ашиглалтын байдлыг танилцуулбал:

- ✓ "Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь" МОН-3338 төслөөс зээл авсан нэг иргэн нь 2023 оны 07 дугаар сарын байдлаар бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж эргэлтийн хөрөнгийг нэмэгдүүлсэн, тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа тул зээлийн хөрөнгийн ашиглалт үр дүнтэй байна.
- ✓ Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ 2000001604 төслөөс 2020-2023 оны байдлаар аймаг дахь Хаан банкны салбараар дамжуулан 9 ААН, 35 иргэнд 931,900.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон ба Хаан банкны зээлийн үйл ажиллагааны журмын 6.10.6.2-т заасны дагуу зээл олгосноос хойш 1 сарын дотор зээлийн зориулалт бүрэн хангагдах хүртэл хугацаанд газар дээрх хяналтыг хийж, баримтаар баталгаажуулдаг байна. 2023 оны 7 дугаар сарын байдлаар зээлийн ашиглалт, гэрээний үүргийн хэрэгжилт хэвийн байна. /Эх сурвалж: Архангай аймаг дахь Хаан банкны 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 5135/431 дугаар албан бичгийг үндэслэв/
- ✓ Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /Нэмэлт санхүүжилт/ 2000001604 төслөөс 2022-2023 оны байдлаар аймаг дахь Төрийн банкны салбараар дамжуулан 38 иргэнд 347,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон ба Төрийн банкны зээлийн үйл ажиллагааны журмын 21.4, 21.6-д заасны дагуу зээл олгосноос хойш 3 сарын дотор зээлийн зориулалтын хяналтыг хийж, баримтаар баталгаажуулдаг байна. 2023 оны 7 дугаар сарын байдлаар зээлийн ашиглалт, гэрээний үүргийн хэрэгжилт хэвийн байна. /Эх сурвалж: Архангай аймаг дахь Төрийн банкны 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 35/477 дугаар албан бичгийг үндэслэв/
- ✓ Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл №112/00236091/210034-1"-ийн хүрээнд 2021 онд 2 иргэн, 2 ААН-д Беларус улсын трактор тоног төхөөрөмжийг 108,220 еврогийн хөнгөлөлттэй зээлээр олгосон ба төсөл хэрэгжүүлэгч нэгжээс төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллаагүй байна. Зээлдэгч нартай уулзалт хийж, трактор, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар тайлбар авахад 2 иргэн, нэг ААН нь трактор, тоног төхөөрөмжийг хэвийн ашиглаж байгаа 2021-2022 онд 1440 га талбайд үр тариа, 900 га талбайд ногоон тэжээл тариалж, хураалтын ажлыг хийж гүйцэтгэжээ. Харин Зээлдэгч “Шир цохио” ХХК нь 2022 оны 03 дугаар сард Хөдөө аж ахуйг дэмжих санд Сэлэнгэ аймгийн иргэн Ж.Батхуягт трактор, тоног төхөөрөмжийг шилжүүлэх хүсэлтийг гаргаж, хүсэлтийн дагуу гэрээг цуцалж тоног төхөөрөмжийг шилжүүлсэн байна.

² Тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрийг 3 жилийн хугацаанд тэнцүү хувааж төлөх ба тухайн жилийн тухайн өдрийн Монгол банкны ханшаар тооцож, энэ гэрээний 2.6-д заасан хуваариар төлнө

³ "Тоног төхөөрөмжийн үлдэгдэл төлбөрт жилийн 1.37 хувийн хүү төлнө"

⁴ "Худалдан авагч нь үйл ажиллагааны зардлыг 1 /нэг/ хувиар тооцож төлнө"



БҮЛЭГ 2. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙГ БҮРЭН АШИГЛААГҮЙ БАЙНА.

Б1. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний зорилго, зорилт нь салбарын бодлоготой уялдсан байна.

Б1.1 Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь урт, дунд, богино хугацааны бодлоготой нийцэж байна.

Архангай аймагт гадаадын буцалтгүй тусламжаар дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөс 2019-2022 онд 2,634.0 сая төгрөгийн 118 төсөл арга хэмжээ
2. "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF" төслийн хүрээнд буцалтгүй тусламжаар 396.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж

Эдгээр арга хэмжээ нь урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байдлыг уялдуулан шалгахад:

- “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөс 2019 онд ХХААХҮЯ-аас эрх шилжээгүй төсөл хэрэгжүүлэгч нэгжээс 598.0 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлсэн нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2019 оны нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлтэй уялдуулж үзэх боломжгүй байна.
- Харин 2020-2022 онд хэрэгжүүлэхээр баталсан 2,036.0 сая төгрөгийн 77 төсөл арга хэмжээ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлд тусгагдсан нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 7 зүйлийн 7.2.1-т⁵ заасантай нийцэж байна.

Хүснэгт-4: Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан байдлыг харуулбал

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	2020 он		2021 он		2022 он	
			2020 оны нийгэм эдийн засгийн хөгжүүлэх үндсэн чиглэл	2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2021 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл	2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2022 оны нийгэм эдийн засгийн үндсэн чиглэл	2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
1	Бог малын угаалгын ванн	12	4	1.2.6	2.1.7	3.2.10		3.2.10
2	Ажлын байр засварлах	1		1.2.4				
3	Малчдын сургалт мэдээллийн төв тохижуулах	1		1.2.4		3.2.1.4		3.2.4.1
4	мал үржлийн тоног төхөөрөмж худалдан авах	1	1.2	1.1.9				
5	Бизнес инкубатор төв шинээр барих	3	3	1.1.9	2.2.7			
6	шинээр барих инженерийн хийцтэй худаг.	55	4	1.2.1	2.1.2.1	3.2.3	3.2.3	3.2.8
7	Өвс тэжээлийн агуулах сававч барих	2			2.1.4.2	3.2.7		3.2.7


⁵ 7.2.1-т төсөл, арга хэмжээний төлөвлөлт болон гэрээ, хэлэлцээрт тусгасан төслийн зорилго, зорилт нь урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байх”



8	Хүнс ногооны зоорь барих	2	1.2.16	2.2.12.1	3.2.12	3.2.11	3.2.11
---	--------------------------	---	--------	----------	--------	--------	--------

- "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF" төслийн хүрээнд Архангай аймгийн 5 сумын 33 өрх, 3 хоршоонд 235.5 сая төгрөгийн сүү боловсруулах, ноос, арьс халимлах багц тоног төхөөрөмжийг, 160.7 сая төгрөгийн инженерийн хийцтэй долоон худгийг буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн нь дараах урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.

Дүрслэл 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан холбогдох заалтаар харуулбал



Б1.2. Тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж байна.

- “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөр 2019-2022 онд нийт 2,634.0 сая төгрөгийн 118 төсөл арга хэмжээ хэрэгжүүлснийг дээр дурдсан. Эдгээр арга хэмжээг он тус бүрээр хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-5: Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслөөр 2019-2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

№	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл	2019-2022 онд хэрэгсэн төсөл		2019 он		2020 он		2021 он		2022 он	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Худаг	61	1,231.4	6	117	44	780.0	11	334		
2	Өвс тэжээлийн агуулах, саравч	3	337.3	1	102			1	97	1	138.1
3	Бог мал угаах ванн	22	242.0	10	80	12	162.1				
4	Оготно устгах тоног төхөөрөмж	15	11.6	15	12						
5	Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө	3	130.0	3	130						
6	Бизнес инкубатор төв шинээр барих	1	109.1			1	109.1				
7	Ажлын байр засварлах	3	131.3	2	88	1	43.6				
8	Хүнс ногооны зоорь	2	288.0					1	119	1	169.4
9	Малчдын сургалт мэдээллийн төв	3	19.3	2	10	1	9.3				



10	Эрсдлийн сан	3	60.0	3	60					
11	Үржлийн мал худалдан авах	1	35.6			1	35.6			
12	Борлуулалтын цэгийн дэмжлэг	1	38.4					2	38	
Дүн		118	2,634.0	42	598.0	60	1,139.7	15	588.8	2 307.5

Уг төслөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг ОНӨГ болон сумын ЗДТГ бүртгэл тайланд тусгаж тухайн нутагт дэвсгэрт оршин суугаа малчид болон Мал эмнэлгийн газартай гэрээ байгуулан хүлээлгэн өгч ашиглуулж байна. Тухайлбал:

- ✓ 2020 онд 12 суманд шинээр хийгдсэн бог мал угаах ванныг ашиглаж 263 өрхийн 223.3 мянган толгой малыг угаалгад хамруулсан.
- ✓ 2021-2022 онд Эрдэнэбулган суманд хэрэгжсэн хүнсний ногооны зоорийг иргэнд гэрээгээр эзэмшүүлэн ашиглуулж байна.
- ✓ 2019 онд 15 суманд хүлээлгэн өгсөн Оготно устгах тоног төхөөрөмжийг сумдын мал эмнэлгийн газарт хариуцуулан шаардлагатай тохиолдол ашиглаж байна. 2019-2022 онд шинээр барьсан инженерийн хийцтэй 1,231.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 худгийн сумын ЗДТГ-т бүртгэж ашиглалтын байдал хэвийн сумын малчидтай гэрээ байгуулж эзэмшүүлэн 700 өрхийн 690 мянга орчим толгой мал усаар хангаж байна. /Эх сурвалж:ЗЗББУХТ-ийн ажлын тайлан/

Зураг-1



Инженерийн хийцтэй 61 худаг



Өвс тэжээлийн агуулах 3



Хүнсний зоорь 2



Бог малын угаалгын ванн 12

- "Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF" төслийн хүрээнд олгосон 91.9 сая төгрөгийн сүү боловсруулах багц тоног төхөөрөмж, 141.9 сая төгрөгийн ноос боловсруулах, арьс халимлах тоног төхөөрөмж нь малчин өрхүүд болон хоршооны үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна. Бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажлыг гүйцэтгэж 7 суманд инженерийн хийцтэй 160.7 сая төгрөгийн худгийг шинээр барьж байгуулсан нь олон нийт, нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан байна.



Эдгээр хөрөнгөнөөс Өндөр-Улаан сумын "Малчин түмний буян" хоршоо нь 80.7 сая төгрөгийн “Арьс халимлах тоног төхөөрөмж”-ийг гүний худаггүйгээс одоогоор ашиглаагүй байна.

Хүснэгт 6: Гадаадын тусламжаар хэрэгжсэн хөрөнгийн ашиглалтын байдал

/сая төгрөг/

ДД	Тусламж авсан хоршоо/сумын өрх/	Мөнгөн дүн	Ашиглагдаагүй хөрөнгө /мөнгөн дүн/	Үйл ажиллагаандаа ашиглаж буй хөрөнгө /мөнгөн дүн/	Нийт ашиглалт-тийн хувь
1	Малчин түмний буян хоршоо	153.80	80.70	73.10	48%
2	Нуурын овоо хоршоо	11.80		11.80	100%
3	Баян уулын хишиг хоршоо	11.80		11.80	100%
4	Ихтамир	12.00		12.00	100%
5	Чулуут	12.00		12.00	100%
6	Хангай	12.00		12.00	100%
7	Тариат	10.30		10.30	100%
8	Өндөр-Улаан	11.80		11.80	100%
9	Инженерийн хийцтэй 7 худаг	160.70		160.70	100%
Нийт дүн		396.20	80.70	315.50	80%

Дээрх хүснэгтээс харахад “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төслөөс олгосон хөрөнгийн ашиглалтын дундаж 80 хувь байна. Үүнийг Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслөөс олгосон хөрөнгийн ашиглалт 100 хувь байгаатай нийлүүлж дунджилбал нийт гадаадын тусламжийн хөрөнгийн ашиглалт 90 хувь гэж үзэж болохоор байна.

Б1.3. Орон нутагт зарим тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний сонгох, үнэлэх, эрэмбэлсэн байдлыг үзэх боломжгүй байна.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн тухайд:

Уг төслөөс 2019-2022 онд орон нутагт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн сонгон шалгаруулалт, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2018 оны 11 сарын 14-ны а/581, 2021 оны 09 сарын 22-ны а/585 дугаар захирамжаар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулсан байна.

Тус ажлын хэсэг нь 2019 онд 2 удаа, 2021 онд 4 удаа, 2022 онд 3 удаагийн хурлыг зохион байгуулж төслөөр хэрэгжүүлсэн 77 төсөл арга хэмжээг сумдын Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн ажлын хэсэг эрэмбэлж төсөл хэрэгжүүлэгч нэгжид хүргүүлсэн байна.

"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF" төслийн тухайд:

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын Техникийн зөвлөх нэгжийн 2018 оны 07 сарын 29-ны өдөр, Хөнгөн үйлдвэрийн салбарын Техникийн зөвлөх нэгжийн 2018 оны 07 сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/424-р тушаалаар техник тоног төхөөрөмж нийлүүлэх иргэн, ААН-ийг баталсан байгаа нь орон нутагт тусламжийн хөрөнгийг сонгох, үнэлэх, эрэмбэлэх ажлуудыг хянах боломжгүй байна.

Б2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажилласан байна.

Б.2.1. Тусламжаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлагыг орон нутагт үзэх боломжгүй байна.



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тушаалаар баталсан “Гадаадын тусламж авах зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 18 дугаар зүйлд заасны дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг төлөвлөхтэй холбоотой ажлуудыг төсөл хэрэгжүүлэгч нэгжээс хэрэгжүүлсэн нь “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтээр хэрэгжсэн 2019 оны 598.0 сая төгрөгийн 42 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн шаардлага хангасан эсэхийг орон нутагт үзэх боломжгүй байна.

- Харин “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөс аймгийн ХАА-н салбарт 2020-2022 онд 2,036.0 сая төгрөгийн 77 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, 100 хувь хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт-7: 2020-2022 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд

№	Хэрэгжүүлэгч	2020 он		2021 он		2022 он		2020-2022 онд хэрэгсэн нийт төслийн дүн	
		тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
1	Хайрхан	3	25.80					3	25.80
2	Эрдэнэмандал	4	74.80	2	56.50		17.40	6	148.70
3	Төвшрүүлэх	5	106.90	1	6.80		16.60	6	130.30
4	Цэнхэр	3	53.40					3	53.40
5	Хотонт	4	74.40	2	104.30		16.60	6	195.30
6	Хашаат	4	74.40					4	74.40
7	Өгийнуур	4	31.90					4	31.90
8	Өлзийт	4	31.90	1	28.20		17.40	5	77.50
9	Батцэнгэл	6	113.20					6	113.20
10	Ихтамир	4	75.30	1	6.80		16.40	5	98.50
11	Тариат	1	20.50					1	20.50
12	Өндөр-Улаан	2	41.10					2	41.10
13	Чулуут	3	61.70					3	61.70
14	Цэцэрлэг	4	74.80	1	28.20		17.40	5	120.40
15	Жаргалант	2	40.90	1	28.20		17.40	3	86.50
16	Хангай	1	20.50			1	138.10	2	158.60
17	Булан	0		1	6.80		16.60	1	23.40
18	Эрдэнэбулган	6	218.10	5	170.70	1	186.00	12	574.80
Дүн		60	1,139.60	15.0	436.50	2.0	459.90	77.0	2,036.00

2020 онд 18 суманд 779.9 сая төгрөгийн 44 инженерийн хийцтэй шинэ худаг, 12 суманд 162.2 сая төгрөгийн бог мал угаалгын ванн, Эрдэнэбулган суманд 109.1 сая төгрөгийн бизнес инкубатор төв, Төвшрүүлэх суманд 43.6 сая төгрөгийн ажлын байр засварлах ажил, 9.2 сая төгрөгийн малчдын сургалт мэдээллийн төв, Цөм сүргийн үржлийн төвд 35.6 сая төгрөгийн үржлийн мал худалдан авах ажлууд хийгджээ.

2021-2022 онд 2 суманд 235.5 сая төгрөгийн 2 өвс тэжээлийн агуулах, 287.9 сая төгрөгийн 2 хүнсний ногооны зoorь, 38.4 сая төгрөгийн 2 бизнес инкубаторын төв, 9 суманд 334.2 сая төгрөгийн 11 худаг, нийт 896.0 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээг хэрэгжүүлжээ.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөө 2019-2022 онд хэрэгжүүлсэн 118 төсөл арга хэмжээний ашиглалтын байдал хэвийн байна. /Эх сурвалж: Аймгийн ОНӨГ-ын 2023.08.01-ны өдрийн 331 дүгээр албан бичгийг үндэслэв/

Хүснэгт-8: Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн нэмэлт санхүүжилт төсийн гүйцэтгэл

№	Санхүүжүүлэгч	Орлого	Зарцуулалт	орон нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлсэн дүн
---	---------------	--------	------------	--



		2020 он	2021 он	2022 он	2020 он	2021 он	2022 он	2020 он	2021 он	2022 он
1	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслөөс	790.4	205.0	297.3	1,139.6	436.6	459.8	89.2	6.7	2.2
2	Орон нутгаас	438.5	160.5	164.5						
Дүн		1,228.9	365.5	461.8	1,139.6	436.6	459.8	89.2	6.7	2.2

Уг төслөөс 2020 онд 89.2 сая, 2021 онд 6.7 сая, 2022 онд 2.1 сая, нийт 98.0 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдсэнээс 8.8 сая төгрөгийг орон нутгийн нэмэлт орлогын дансанд төвлөрүүлсэн, 89.2 сая төгрөгийг он дамжин хэрэгжсэн төслийн гүйцэтгэгчид олгожээ.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөр 2019-2022 онд орон нутагт хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байдлыг авч үзвэл:

2019 онд Инженерийн хийцтэй худаг, өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих, үлийн цагаан оготно устгах тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг ХХААХҮЯ-аас зохион байгуулж гэрээ байгуулсан байна. Харин ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн А/117 дугаар тушаалаар бог мал угаалгын ванн, эмэгтэйчүүдийн бүлгүүдийн ажлын байр засварлах ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг орон нутагт шилжүүлсэн боловч аймгийн ОНӨГ-аас дээрх 2 төсөл арга хэмжээ нь 2020 оны төлөвлөгөөнд байхгүй, орон нутагт эрх шилжээгүй, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй гэсэн тайлбарыг ирүүлээд байна /Эх сурвалж: ЗЗБУХТ-ын 2023.07.17-ны 82/23 тоот албан бичиг, мөн аймгийн ОНӨГ-ын 2023 оны 08 сарын 01-ны өдрийн 331 тоот албан бичгүүд/

2020 онд ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн А/65 дугаар тушаалаар Зах зээл удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслийн хөрөнгөөр Архангай аймагт хэрэгжүүлэх 1,404.5 сая төгрөгийн 44 инженерийн хийцтэй худаг, 12 бог мал угаалгын ванн, малчдын сургалт мэдээллийн төвийн тохижилт, ажлын байр засварлах, мал үржүүлгийн тоног төхөөрөмж, бизнес инкубатор төв барих зэрэг 60 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсний дагуу аймгийн ОНӨГ-аас худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчдийг сонгон шалгаруулж 1,139.7 сая төгрөгийн гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн засаг даргад хүргүүлэн ажиллажээ.

2021-2022 онд ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн А/35 дугаар тушаалаар 683.0 сая төгрөгийн 16 ажил, 2022 оны 02 сарын 10-ны өдрийн А/45 дугаар тушаалаар 730.0 сая төгрөгийн 3 ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлсний дагуу аймгийн ОНӨГ нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.



Дүрслэл-1



- “Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих” ТА-8960 МОН төслийн хүрээнд Архангай аймгийн 5 сумын 33 өрх, 3 хоршоонд 235.5 сая төгрөгийн багц тоног төхөөрөмжийг, 160.7 сая төгрөгийн инженерийн хийцтэй 7ш худгийг шинээр барьж байгуулсан байна. Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах бүртгэх, тайлагнах журам”-ын 7.1, 7.2, 7.3 дахь заалтыг баримтлан төслийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнах, үнэлэхэд баримтлах зарчмыг мөрдлөг болгон ажиллажээ.

Б.2.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дууссаны дараа үр дүнг тооцож ажилласан байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслийн тухайд:

Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журам”-ын дагуу хяналт хэрэгжүүлсэн байдлыг удирдлагын мэдээллийн систем /ODAMIS/-ийн мэдээлэл болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-аас Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн 2019 оны жилийн эцсийн тайлан, 2020 оны эхний хагас ажлын тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлийг 88.3% буюу “Хангалттай” гэж үнэлжээ.
2. Төсөл, хэрэгжүүлэгч нэгжээс 2020, 2021 оны байдлаар төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт хийж, тайланг ХХААХҮЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлжээ.
3. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас 2020, 2021 оны төслийн хэрэгжилтэд хяналт хийж төслийн ерөнхий хэрэгжилтийг (5) буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна.
4. 2022 онд санхүүжүүлэгч байгууллагаас 3 удаагийн хяналт үнэлгээг хийж өмнөх өгсөн үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлт, төсөлтэй хамтрагч талууд болох төрийн байгууллага, төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг, санхүүжилт, зарцуулалт болон 2022 оны хөрөнгө оруулалтын ажилд орон нутгийн оролцооны 50%-ийг оруулсан эсэхэд хяналт хийж нийт төслийн хэрэгжилтийг (5) буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна. /Эх сурвалж: Dmfas, odamis системээс/
5. аймгийн ГХБХБГ, ХХААГ болон Мал эмнэлгийн газраас 2020-2022 онд 17 суманд шинээр барьсан инженерийн хийцтэй 44 худаг, 12 суманд хийсэн бог малын угаалгын ванн, Эрдэнэбулган суманд баригдсан Бизнес инкубатор төв, Төвшрүүлэх суманд хийсэн ажлын байрны засварын ажлуудад үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.



"Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF" төслийн тухайд:

Удирдлагын мэдээллийн систем /ODAMIS/-ийн мэдээллээс харахад Төслийн удирдах хороо (ТУХ)-ны бүтэц, бүрэлдэхүүнийг ХХААХҮ-ийн сайдын 2020.11.03-ны А356 тоот тушаалаар ХХААХҮЯ-ны 7, СЯ-ны 2, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам (БОНХЯ)-ны 1 болон Монголбанкны 1 төлөөллийг оролцуулан төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт тавин ажилласан байна.

Төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд АХБ, яамдууд, мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээний байгууллага болон олон улсын санхүүгийн байгууллагаар төслийн үйл ажиллагааны хяналт, мониторинг хийх, тайлагнах, үйл ажиллагаа ЗГ-ын болон Сангийн сайдын холбогдох журмуудын дагуу хийгдэн үр дүнг тооцсон байна. /<https://odamis.mof.gov.mn/login/>

БҮЛЭГ 3. ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ БАГАТАЙ БАЙНА.

В1. Зарим зээл, тусламжийн хөрөнгийг олгох, хэрэгжүүлэх, ашиглахад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

В1.1. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн төслүүдийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна.

Архангай аймгийн хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжсэн 4 төслийн 2016-2022 оныг хамруулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, мэдээллийн ил тод байдлыг шалгалаа. Төсөл тус бүрээр танилцуулбал:

- “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил /2000001604/” төслийн мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2018 онд 82%, 2019 онд 59%, 2020 онд 67.6%, 2021 онд 92.1%, 2022 онд 89.9%-тай байна.
- “Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх МОН-3338” төслийн мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт 2016 онд 18.4%, 2017 онд 50%, 2018 онд 47.8%, 2019 онд 69.9%, 2020 онд 74.3%, 2021 онд 84.6%, 2022 онд 93.4%-тай байна.
- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт 3288-MON SF” төслийн төсөл хэрэгжүүлэгч нэгж нь 2016-2020 онуудад шилэн дансны системд бүртгүүлээгүй, мэдээллийг огт байршуулаагүй, 2021 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилт 21.9 хувьтай байна.
- БНБеларус улсын хөгжлийн банкнаас “Трактор Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх №112/00236091/210034-1” төсөл нь 2016-2023 онд хэрэгжиж байгаа боловч шилэн дансны нэгдсэн системд одоог хүртэл бүртгэлгүй байна.

Хүснэгт 9: Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн шилэн дансны хэрэгжилт

Төсөл хөтөлбөр	Он	Нийт	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа	Мэдээлээгүй	Хуулийн хэрэгжилт /хувь/
		мэдээлэл байшуулах тоо		хоцорч мэдээлсэн		
ЗЗББУХ	2018	139	114	23	2	82.0
	2019	139	82	57	0	59.0
	2020	139	94	44	0	67.6
	2021	139	128	11	0	92.1
	2022	139	125	14	0	89.9



Зээлийн батлан даалт	2016	136	25	87	28	18.4
	2017	136	68	55	13	50.0
	2018	136	65	58	13	47.8
	2019	136	95	28	13	69.9
	2020	136	101	22	13	74.3
	2021	136	115	21	0	84.6
	2022	136	127	9	0	93.4
ХАА хөдөөгийн хөгжил	2016-2020	Шилэн дансны системд мэдээлэл огт байршуулаагүй				
	2021	151	33	0	118	21.9
Трактор ХАА техник нийлүүлэх төсөл	Шилэн дансны системд бүртгэлгүй					

БНБеларус улсын хөгжлийн банкнаас “Трактор Хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмж нийлүүлэх” төсөл, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилт” төслийг шилэн дансны системд бүртгүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах саналыг төсөл хэрэгжүүлэгч нэгжид УАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

В1.2. Зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, арга хэмжээнд эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах журам”-ыг мөрдөн эрх бүхий байгууллагууд хяналт тавьж ажилласан эсэхийг үзэхэд:

- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл хэрэгжих хугацаанд төслийн хяналт шинжилгээ үнэлгээний журмын дагуу хяналт шинжилгээ хийж ХХААХҮЯамны ХШҮДАГазарт хугацаанд нь хүргүүлэн ажиллажээ. Мөн Үндэсний аудитын газар жил бүрийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн, Архангай аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2019-2022 оны 3-р улирлын төсөв санхүү болон төслийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.
- Зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах замаар эдийн засгийг төрөлжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх төслийн 2020 оны санхүү, төслийн үйл ажиллагаанд төслийн хяналт шинжилгээний баг хяналт тавьж ХХААХҮЯамны ХШҮДАГазарт хүргүүлсэн байна. Уг төслөөс Хас банкаар дамжуулан нэг иргэнд 10.8 сая төгрөгийн зээл олгож, банкнаас зээлийн гэрээний үүргийн хэрэгжилтэд хагас жил тутам хяналт тавьж ажиллажээ.
- Хөдөө аж ахуй хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төсөл хэрэгжих хугацаанд төслийн хяналт шинжилгээ үнэлгээ журмын дагуу хяналт шинжилгээ хийж ХХААХҮЯамны ХШҮДАГазарт хугацаанд нь хүргүүлжээ. Үндэсний аудитын газар 2018, 2020, 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийсэн мөн “Далайван аудит” ХХК-н 2016-2017, 2019, 2020-2021 оны санхүү, үйл ажиллагаанд аудит хийж тайланг баталгаажуулсан байна.
- БНБеларус улсын хөгжлийн банкнаас Трактор Хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөлд эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна



Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаад тусламж авах, зарцуулах, удирдах, тайлагнах журам”-ын 23 дугаар зүйл, 24.9.2.2, 25.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар саналыг ХХААХҮЯ болон төсөл хэрэгжүүлэгч нэгжид ҮАГ-аар уламжлуулан хүргүүлж байна.

В1.3. Зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний 14.3 хувийг бүртгэж тайлагнаагүй байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөс 2019-2022 онд 2,634.0 сая, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF төслөөс 396.2 сая нийт 3,030.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэнээс 2,597.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэж, 433.2 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна. Үүнд:

- “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилтийн төслөөс 2019-2022 онд 12 төрлийн 2,634.0 сая төгрөгийн 118 төсөл арга хэмжээ хэрэгжсэнээс 6.6 хувь буюу 174.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн ⁶14.4, 14.4.2⁷ дахь заалттай нийцэхгүй байна. Үүнд:
 - ✓ Хайрхан, Эрдэнэмандал, Төвшрүүлэх сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө нийт 130.0 сая төгрөг,
 - ✓ Жаргалант, Өлзийт суманд 2021 онд шинээр барьсан инженерийн хийцтэй худаг нийт 44.2 сая төгрөг

Хүснэгт 9. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслөөс 2019-2022 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээ

№	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төсөл	2019-2022 онд хэрэгжсэн төсөл		2019 он		2020 он		2021 он		2022 он	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Худаг	61	1,231.4	6	117.0	44	780.0	11	334.4		
2	Өвс тэжээлийн агуулах, саравч	3	337.3	1	101.8			1	97.4	1	138.1
3	Бог мал угаах ванн	22	242.0	10	79.9	12	162.1				
4	Оготно усгах тоног төхөөрөмж	15	11.6	15	11.6						
5	Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө	3	130.0	3	130.0						
6	Бизнес инкбатор төв шинээр барих	1	109.1			1	109.1				
7	Ажлын байр засварлах	3	131.3	2	87.7	1	43.6				
8	Хүнс ногооны зоорь	2	288.0					1	118.6	1	169.4
9	Малчдын суралт мэдээллийн төв	3	19.3	2	10.0	1	9.3				
10	Эрсдлийн сан	3	60.0	3	60.0						
11	Үржлийн мал худалдан авах	1	35.6			1	35.6				
12	Борлуулалтын цэгийн дэмжлэг	1	38.4					1	38.4		
	Дүн	118	2,634.0	42	598.0	60	1,139.7	14	588.8	2	307.5

Аудитаас уг төслөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэл тайланд тусгаагүй Хайрхан Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Өлзийт, Жаргалант сумдын ЗДТГ-ын дарга нарт хөрөнгийг бүртгэлд тусгах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

- “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн Нэмэлт санхүүжилт 3288-MON SF төслөөс 33 өрх, 3 хоршоонд хандиваар олгосон 235.5 сая төгрөгийн Сүү боловсруулах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг акт үйлдэн өрх, хоршоо тус

⁶ 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”

⁷ 14.4.2-т Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага



бүрд хүлээлгэн өгсөн боловч бүртгэл тайландаа тусгаагүй, ТӨБЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 250 дугаар тогтоолоор төслийн нэгжийн хөрөнгөнөөс шилжүүлэн аймгийн орон нутгийн өмчид бүртгэх зөвшөөрөл олгосон Жаргалант сумын Зуслан багийн Таравтад шинээр барьж байгуулсан 23.6 сая төгрөгийн худгийг тус сумын ЗДТГ нь үндсэн хөрөнгөнд бүртгээгүй байна.

Өөрөөр хэлбэл дээрх төслөөс буцалтгүй тусламжаар шинээр бий болсон нийт үндсэн хөрөнгүүдийг аймгийн ОНӨГ-ын бүртгэлтэй тулган шалгахад 65.4 хувийг бүртгэл тайланд тусгаагүй зөрчил илэрлээ. /Эх сурвалж: Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн 329 дугаар албан бичгийг үндэслэв/

Хүснэгт 10. ХАА, хөдөөгийн хөгжил төслийн бүртгэл тайланд тусгаагүй хөрөнгүүд

ДД	Тусламж авсан хоршоо/сумын өрх/	Мөнгөн дүн	Тайланд тусгагдаагүй хөрөнгө/мөнгөн дүн/	Тайланд тусгагдсан хөрөнгө/мөнгөн дүн/	Бүртгэлд тусгаагүй хувиар
1	Малчин түмний буян хоршоо	153.80	153.8	0	100%
2	Нуурын овоо хоршоо	11.80	11.80	0	100%
3	Баян уулын хишиг хоршоо	11.80	11.80	0	100%
4	Ихтамир -7 өрх	12.00	12.00	0	100%
5	Чулуут -7 өрх	12.00	12.00	0	100%
6	Хангай -7 өрх	12.00	12.00	0	100%
7	Тариат -6 өрх	10.20	10.20	0	100%
8	Өндөр-Улаан -6 өрх	11.80	11.80	0	100%
9	Инженерийн хийцтэй 7 худаг	160.80	23.60	137.20	14.70%
Нийт дүн		396.20	259.00	137.20	65.40%

Үндсэн хөрөнгийг бүртгэл тайлан тусгах Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмж, албан шаардлагыг холбогдох байгууллагуудад хүргүүллээ.



АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

1. Засгийн газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байна.
2. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийг бүрэн ашиглаагүй байна.
3. Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөө багатай байна.

АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

АРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ 90 ХУВЬТАЙ, НИЙТ ХӨРӨНГИЙН 14.3 ХУВИЙГ БҮРТГЭЛ ТАЙЛАНД ТУСГААГҮЙ БАЙНА.

Аудитын дүн: Аудитаар нийт 390.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 212.7 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 177.5 сая төгрөгийн зөрчилд 3 заалт бүхий зөвлөмжийг Жаргалант, Өлзийт, Төвшрүүлэх, Хайрхан, Эрдэнэмандал сумын ЗДТГ-т болон гадаадын зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгийг ашиглагч нэр бүхий иргэн, ААН-д хүргүүлээ.

Аудитын тайлангаар Үндэсний аудитын газраар уламжлуулан төслийн нэгжид 2 саналыг хүргүүлж байна.

-----oOo-----

\\



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглагч “Нуурын овоо”, “Баян уулын хишиг”, “Малчин түмний буян” хоршооны удирдлагуудад

1. “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл 3288-MON SF” төслөөс 2022 онд “Малчин түмний буян” хоршоонд 153.8 сая төгрөгийн, “Нуурын овоо” хоршоонд 11.8 сая төгрөгийн, “Баян уулын хишиг” хоршоонд 11.8 сая төгрөгийн сүү, мах, арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар нийлүүлсэн байх тул дээрх хөрөнгүүдийг хоршооны үндсэн хөрөнгөнд бүртгэж тайлагнах

